

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. “Монголросцветмет” ХХК нь Баяжуулах фабрикийн хаягдлын аж ахуйн иж бүрэн мониторинг түүний цаашдын ашиглалтын төсөл зөвлөмж боловсруулах ажил (тендерийн дугаар [МРЦМ/201901194](#))-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет”ХХК-ийн Бор-Өндөр УБҮ-ийн баяжуулах фабрикийн хаягдлын аж ахуйн ашиглалтад хяналт, мониторинг хийж, цаашдын ашиглалтын төсөл, зөвлөмжийг боловсруулах ажлыг гүйцэтгэж, үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээмжийг өсгөх, хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах боломжоор хангахад чиглэгдэнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ.

- Байгууллагын гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар
- Барилга байгууламж /уулын баяжуулах үйлдвэрлэлийн хаягдлын аж ахуй, гидротехникийн байгууламж/-ийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл 1.3.5, 1.4.2, 1.5.1 (Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 33 дугаар тушаалаар батлагдсан аргачлалыг дүйцүүлнэ)
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2016,2017,2018 (Сүүлийн гурван жилд тухайн чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Төслийн гүйцэтгэх баг нь ижил төстэй ажил дээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, багийн бүрэлдэхүүнд геотехникийн болон усан сан, гидротехникийн байгууламжийн мэргэшсэн/зөвлөх зэрэглэлтэй 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай инженертэй байх
- Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn –ын татварын өргүй тухай тодорхойлолт
- Аудитлагдсан 2017, 2018 оны санхүүгийн тайлан

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Гадаадын этгээд оролцох эрхгүй.

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө дор дурдсан хаягаар ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ **2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 15:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ХХК

Хаяг: Улаанбаатар хот-51, ш/х-002

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо,

“Монголросцветмет”ХХК-ийн өөрийн байр, өрөө: 305

И-майл: mailbox@monros.mn

Утас: 458072, 453482, факс 458380